2021 Хичээлийн жилийн ирцийн дүрмийн талаарх зааварчилгаа

Эрхэм хүндэт эцэг эх танаа

20 Хичээлийн жилд эцэг эхчүүд та бүхний гэр бүлд эрүүл энх аз жаргалыг хүсье.

[Сурагчийн амьдралын бүртгэл хөтлөх, удирдан зохион байгуулах заавар_Боловсролын яамны 280 тоот удирдамж] -ын дагуу тус сургуулийн ирцийг хянах дүрмийг танилцуулж байна. Нэмж дурдахад, хүүхдүүд маань эрүүл зөв өсч бойжиход эцэг эхчүүд анхаарлаа хандуулан сургуультай нягт холбоотой ажиллахыг хүсэж байна.

1. **Ирцийн явцыг хянах**

Ирц

1) Хичээлд хамрагдаагүйд тооцох тохиолдол

: Сургуулийн журамд заасны дагуу тухайн сурагч нь хичээлд хамрагдах шаардлагатай өдрүүдэд хичээлд хамрагдаагүй тохиолдолд хичээл тасалсанд тооцно.(Анги удирдсан багштай холбоо барих нь ирцийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг биш юм.)

2) Хичээлээс чөлөөлөх

А) Газар хөдлөлт, аадар бороо, их цас, шуурга, цунами гэх мэт байгалийн гамшиг болон халдварт өвчин зэрэг (сургуульд тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн захирал шаардлагатай хэмээн хүлээн зөвшөөрсөн тохиолдолд) хичээлд хамрагдаагүй тохиолдолд

Б) Сургуулийн захирлын зөвшөөрлөөр сургууль / хот (боловсролын газар) -ыг төлөөлж тэмцээн уралдаан, сургалтанд хамрагдаж харилцан туршлага солилцох, **сургуулиас гадуур туршлага судлах** (арын хуудаснаас харна уу) зэрэг тохиолдолд 「Сургуулийн эрүүл мэндийн тухай хууль」ийн 8 дугаар зүйлд заасны дагуу хичээлээс чөлөөлөх” зэрэг шалтгаанаар хичээлд хамрагдаагүй тохиолдолд

В) 「Бага, дунд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг хангах тухай тогтоол" -ын 31-р зүйлийн 1-т заасны дагуу сургууль доторх сайн дурын ажил, олон нийтийн сайн дурын ажил, тусгай боловсрол эзэмших хугацаа гэх мэт

Г) 「Бага, дунд боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу зөвлөгөө авах, эмчилгээ хийлгэх хөтөлбөр зэрэгт хамрагдахыг хүлээн зөвшөөрөх хугацаа

Д) Дараах баярт болон эмгэнэлт үйл явдал зэргээс шалтгаалан хичээлд хамрагдаагүй тохиолдолд **-(баяр ёслол болон эмгэнэлт үйл ажилгаанд оролцох бичиг) хүлээлгэн өгөх［маягт1］**

【Дараах баярт болон эмгэнэлт өдрүүдэд ирцийг хичээлд хамрагдсанаар хүлээн зөвшөөрөх өдөр】

төрөл	хамрах хүрээ	Өдрийн тоо	Тайлбар
Хурим	·Төрсөн ах эгч нар	1	※ Амралтын өдөр болон бүх нийтийн амралтын өдөр нь баярт болон эмгэнэлт үйл ажиллагааны улмаас чөлөөлсөн өдрийн тоонд хамаарахгүй ба дараалласан олон хоногийн чөлөө олголтод хамаарна.
Үрчлэгдэх	·Өөрийн бие	20	
Оршуулга	·Эцэг эх, эмээ өвөө	5	
	·Эцэг эхийн өвөө, эмээ ·Ах, эгч, түүний эхнэр нөхөр	3	
	·Эцэг эхийн ах эгч	1	

Е)Сарын тэмдэг ихээр өвдөлттэй ирдэг сурагчид нь сургуулийн захирлын зөвшөөрлөөр хичээлээс чөлөөлнө. (Сард 1удаа)

3) Өвчний улмаас хичээлд хамрагдаагүй ［маягт2］ хичээлээс чөлөөлөгдөх бичиг шаардагатай

А) Хөнгөн өвчнөөр өвдсөн үед 1-2 хоногийн **богино хугацааны хичээл таслалт**: хичээлд хамрагдаагүй өдрөөс хойш 5 хоногийн дотор

① Хичээлээс чөлөөлөгдөх бичиг хүлээлгэн өгөх+② Анги удирдсан багшийн зөвшөөрөл

Б) Өвчний улмаас 3с дээш хоног **удаан хугацааны хичээл таслалт**: хичээлд хамрагдаагүй өдрөөс хойш 5 хоногийн дотор

① Хичээлээс чөлөөлөгдөх бичиг +② Эмчийн дүгнэлт , (Эмчийн бичиг, эмчилгээний баталгаа, эмнэлэгт хэвтэн эмчлүүлж гарсныг батлах бичиг зэрэг эмчилгээтэй холбоотой хавсаргасан баримт бичиг)

В) Суурь өвчтэй хэт мэдрэмтгий сурагчийн нарийн тоосжилттоос хамааралтай хичээл таслалт

① Хичээлээс чөлөөлөгдөх бичиг +② Эмчийн дүгнэлт (Эмчийн бичиг)

※ Хичээлийн улирлийн эхэнд эмчийн тодорхойлолт хүлээлгэн өгсөн тохиолдолд улирлийн явцад өвдөхөд дахин өгөх шаардлагагүй

4) Нотлох шаардлагагүй хичээл таслалт (хичээлээс чөлөөлөх бичиг шаардлагагүй)

А) 「Сургуулийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээний тухай хууль」 17 дугаар зүйл 1 дэх хэсгийн 6-д заасны дагуу хичээлээс түр чөлөөлөх.

Б) 「 Бага, дунд боловсролын тухай хуулийн шийдвэрийг хэрэгжүүлэх хууль」 31 дүгээр зүйл 1 дэх хэсэг 4-т заасны дагуу хичээлээс түр чөлөөлнө.

Г) 「 Бага, дунд боловсролын тухай хуулийн шийдвэрийг хэрэгжүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйл 6 дахь хэсэгт заасны дагуу гэрээр суралцах хугацаанд

Д) Хайхрамжгүй байдал, оргон зайлах, хичээлд хамрагдахаас татгалзах зэрэг санаатайгаар хичээлд хамрагдаагүй тохиолдолд

Е) Бусад үндэслэлгүй шалтгаанаар хичээлд хамрагдаагүй тохиолдолд

※ Хичээлээс гадуур туршлага судлах хугацааг хэтрүүлсэн эсвэл гадаадад хэлний бэлтгэлд хамрагдсаны улмаас хичээлд хамрагдаагүй

5) Бусад таслалт (сургуулийн захирал хүлээн зөвшөөрсөн: албан бичигт гарын үсэг зурсан байх)

А) Эцэг эх гэр бүлээ тэжээх, гэрийн ажилд туслах, асарч хамгаалах гэх мэт хувийн зайлшгүй нөхцөл байдлаас шалтгаалан хичээлд хамрагдаагүйг **<u>сургуулийн захирал хүлээн зөвшөөрөх тохиолдолд</u>**

Б) Бусад үндэслэлтэй шалтгаанаар хичээлд хамрагдаагүйг **<u>сургуулийн захирал хүлээн зөвшөөрөх тохиолдолд</u>**

2. Сургуулиас гадуурх туршлага судлах〔маягт 3, 4〕

◆ **Үйл ажиллагаа** ◆

А. Сургуулиас гадуурх туршлага судлах гэдэг нь хувийн төлөвлөгөөний дагуу сургуулийн захирлаас урьдчилан зөвшөөрөл авсны дараа явуулсан туршилт сургалт бөгөөд энэ хугацааг амралтын өдөр, сургуулийн амралт, бүх нийтийн амралтын өдрүүдийг эс тооцон **жилд 10 хоног**ийг хичээлд хамрагдсанаар тооцно

Б. Сурагчийн сургуулиас гадуурх туршлага судлах гэдэг нь ажиглалт, судалгаа, цуглуулга, хээрийн аялал, хайгуул, соёлын туршлага зэрэг шууд туршлагын үйл ажиллагаа, дадлагад анхаарлаа төвлөрүүлж, боловсролын үр нөлөөг харуулсан өргөн хүрээний туршилт сургалтыг хэлнэ.

В. Зарчмын хувьд сургуулиас гадуур туршлага судлах хугацаа нь 1 өдөр бөгөөд шаардлагатай тохиолдолд хагас өдөр (4 цаг)явуулж болно.

(4 цагаар 2 удаа явагдсан тохиолдолд 1 өдрөөр тооцно)

Г. Сурагч нь сургуулийн гадуурх төрөл бүрийн туршлага судлах ажилд гадаад, дотоодын хайгуул хийх туршлага судлах үйл ажиллагаанд оролцохыг хүсвэл зайлшгүй **асран хамгаалагчийн зөвшөөрлөөр явагдах** ёстой.

◆ **Бүртгүүлэх үе шат** ◆

А. Асран хамгаалагч нь туршлага судлах ажил эхлэхээс 3 хоногийн өмнө (бямба, ням, амралтын өдрүүдээс бусад) хотоос гадуур туршлага судлах төлөвлөгөө гаргаж, 〔Маягт3〕 сургуулиас гадуур туршлага судлах өргөдлийг бөглөн анги удирдсан багшид хүлээлгэн өгнө.

В. Удирдагч нь **асран хамгаалагч, асран хамгаалагчийн зөвшөөрсөн насанд хүрсэн хүн** байна..

Г. Сургуулийн захирал өргөдлийг хүлээн авсны дараа сургуулиас гадуурх туршлага судлах зайлшгүй шаардлага болон сургуулиас гадуурх туршилтыг үр дүнтэй гүйцэтгэх боломжтой эсэхийг тодорхойлж, сургуулиас гадуурх туршлага судлах ажлыг батлана.

Д. Сургуулиас гадуурх туршлага судлах ажилд гарахаас өмнө сурагч болон эцэг эх нь сургалтын үед анхаарах зүйл, туршлага судлах арга зэргийн талаар мэдээлэл аван, туршилт сургалтыг эхлэнэ

Е. Сургуулиас гадуурх туршлага судлах өргөдлийн агуулгаас өөрөөр хуурамчаар туршлага судлах ажлыг хийсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөөгүй хичээл таслалтаар тооцох болно.

Ё. Сурагч нь туршлага судлах ажил дуусаны дараа 7 хоногийн дотор〔Маягт 3〕сургуулиас гадуурх туршлага судлах ажлын тайлан (гадаадад туршлага судласан тохиолдолд нотлох баримт бичиг: цагаачлалын хяналтын бичиг, тасалбар) ирүүлж, анги удирдсан багш (сургууль) зохих газар хүлээлгэн өгөх шаардлагатай. Гэхдээ гадаадад амьдардаг хамаатан садныдаа зочлох тохиолдолд асран хамгаалагчгүй UM (Unaccumpanied Minor) үйлчилгээг ашиглаж болно.

※ Сургуулиас гадуурх туршлага судлах ажлыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд (хичээлд хамраагдаагүйд тооцно)

- Бусад сургалт, шашны байгуулгаас зохион байгуулсан бүх үйл ажиллагаа
- Насанд хүрсэн 1 хүн 1 сурагч биш олон тооны сурагчийг хамарсан бүх үйл ажиллагаа

о оБага сургуулийн захирал